



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 1537

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Зэсгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн хөрөнгөөр Есөнбулаг сумын Жинст багийн нутаг дэвсгэрт баригдсан 12 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.


Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандаххүү	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Д.Отгонжаргал	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	П.Аззаяа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн улсын байцаагч)
	Б.Цэрэндаваа	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)
	А.Дэлгэржаргал	("Солонго дулааны станц" ААТҮГ-ын захирал)
	Г.Хүрэлхүү	("Ундарга-Алтай" ААТҮГ-ын ерөнхий инженер)

2.

Н.Золжаргал	(Есөнбулаг сумын Засаг даргын орлогч)
Б.Нямжаргал	(Алтай хотын Захирагчийн албаны архитектур, барилга, нийтийн аж ахуй хариуцсан мэргэжилтэн)
Д.Баярчулуун	(“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн эрэлтийн хамгааллын инженер)
Д.Цэвэлмаа	(“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн ерөнхий инженер)
Ш.Ариунаа	(Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн зөвлөлийн дарга)
А.Бямбадорж	(Есөнбулаг сумын иргэн) (ашиглагч)
О.Алтанбагана	(“Люкс товер” ХХК-ийн захирал) (зохиогч)
Ц.Ариузаяа	(“Хантайшир ван” ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга: Д.Төгсбаяр	(Есөнбулаг сумын иргэн) (захиалагч)

2.Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР